



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 11/69

Улаанбаатар хот

### Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Соёлын төв өргөөний их танхимд ажлын зайлшгүй шаардлагаар гэрээ байгуулсны үндсэн дээр үнэ төлбөргүйгээр зохион байгуулагдах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээний жагсаалтыг хавсралтанд дурьдсаны дагуу баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахад Соёлын төв өргөөнөөс гарах ашиглалтын зардлыг зөвшөрөл авч, тус байгууллагын нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогоос хасч тооцож байхыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/, захирамжийн хэрэгжилттэй холбоотой санхүүгийн бүртгэл тооцоог улирал бүр хийж байхыг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/, Соёлын төв өргөө /Б.Байгалмаа/-нд тус тус даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2011 оны 793 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Н.Батаад үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Э.БАТ-ҮҮЛ

111020000210

Нийслэлийн Засаг даргын 2013 оны  
01 дугаар.....сарын 18.....-ны өдрийн  
1/33 дугаар.....захирамжийн хавсралт

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ИХ ТАНХИМД  
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЯВУУЛАХ ЗАРИМ ЁСЛОЛ,  
ХҮНДЭТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

1. Үндэсний их баяр наадам, улс тунхагласны өдөр, нийслэл хот байгуулагдсаны өдөрт зориулсан баярын хурал, хүндэтгэлийн концерт, ахмадын баяр.

2. Монгол туургатны их наадам.

3. Засгийн газрын тогтоолоор батлагдсан найрамдалт орнуудын соёлын өдрүүд, Монгол улстай дипломат харилцаа тогтоосон түүхэн тэмдэглэлт, тэгш ойн арга хэмжээ, Улаанбаатар хоттой ах дүү найрамдалт хотуудын соёлын болон кино өдрүүд, улс, төрийн өндөр айлчлалд зориулсан арга хэмжээ.

4. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны "Журам батлах тухай" 172 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тэгш ойг нь тэмдэглэхээр шийдвэрлэсэн нийслэлийн төсөвт байгууллагуудын ойн арга хэмжээ.

4. Нийслэлийн Засаг даргын мэрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн төр, захиргааны байгууллагуудаас зохион байгуулах хурал, чуулган, уулзалт, зөвлөлгөөн.